



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 07 сарын 25 өдөр

Дугаар 210

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Баянчандмань АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 4 нэрийн, нийт 343,606,031.00 (гурван зуун дөчин гурван сая зургаан зуун зургаан мянга гучин нэг) төгрөгийн балансын үнэ бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 26,960,000.00 (хорин зургаан сая есөн зуун жаран мянга) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. "Баянчандмань АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Б.Мөнхгэрэлд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ





Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2024 оны 04 дугаар сарын 23 өдрийн
2/0 дугаар тогтоолын хавсралт

"БАЯНЧАНДМАНЬ АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ӨРТӨГҮЙ, ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАЖ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Шинэчлэн тогтоох нийт үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил
1	Доргиурт индүү / том сакай/	6/30/2006	1	111,180,700.00	111,180,700.00	11,120,000.00	2
2	Контейнер 20 тн	1/1/1994	1	627,700.00	627,700.00	960,000.00	2
3	Ниссан патрул, JN1TCSY61Z0579516, 35-52 ТӨВ	1/1/2011	1	67,846,520.00	67,846,520.00	6,880,000.00	2
4	Камаз /усны машин/, ХТС65115382350313, 76-92 ТӨҮ	9/15/2009	1	163,951,111.00	163,951,111.00	8,000,000.00	2
				343,606,031.00	343,606,031.00	26,960,000.00	
	Нийт дүн				(гурван зуун дөчин гурван сая зургаан зуун зургаан мянга гучин нэгэн мөнгө)	(хорин зургаан сая есөн зуун жаран мянга)	